

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙГ ШИЛЖҮҮЛЭХ, СЭЛГЭН АЖИЛЛУУЛАХ ТУХАЙ ЗАР

Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журмын 4 дүгээр зүйлийн 4.2-т заасны дагуу төрийн өөр байгууллага, нэгж хооронд шилжин ажиллахыг хүссэн төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдыг дараах албан тушаалд холбогдох материалаа цахим шуудангаар ирүүлэхийг урьж байна.

Тавигдах болзол, шаардлага:

- төрийн жинхэнэ албан тушаалд зохих ёсоор томилогдсон байх;
- зарлагдсан албан тушаалтай адил төрөл болон адил ангилалд ажилладаг байх;
- зарлагдсан албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг хангасан байх.

Бүрдүүлэх материал:

- Төрийн албан хаагчийн анкет;
- Иргэний үнэмлэхийн хуулбар;
- Боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичиг /диплом/, хэрэв гадаад улсад их, дээд сургууль төгссөн бол боловсролын баримт бичгийн баталгаат орчуулгыг хавсаргах;
- Мэргэшүүлэх сургалтад хамрагдсаныг гэрчлэх баримт бичиг;
- Нийгмийн даатгалын дэвтэр /Хөдөлмөрийн дэвтэр/-ийн хуулбар, цахим лавлагаа;
- Албан тушаалд томилогдсон, чөлөөлөгдсөн тушаал, шийдвэрийн хуулбар;
- Төрийн жинхэнэ албаны тангараг өргөсөн “Тангаргийн хуудас” хуулбар;
- Сүүлийн гурван жилийн төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлсэн илтгэх хуудас, төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээ;
- Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт /e-mongolia–аас татан авах/.

Материал хүлээн авах:

- Хугацаа: 2023 оны 05 сарын 05-ны өдрийн 17.00 цаг хүртэл
- Хүлээн авах хаяг: michidmaa@csc.gov.mn цахим шуудангаар
- Холбоо барих утас: 264216

Шилжүүлэх, сэлгэн авах ажлын байрны жагсаалт

№	Байгууллага	Дотоод нэгж	Албан тушаал	Орон тоо	Албан тушаалын		Албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлага			
					төрөл	ангилал, зэрэглэл	Боловсрол	Мэргэжил	Мэргэшил	Туршлага
1	ТАЗ, Ажлын алба	ЗУГ	Газрын дарга	1	Төрийн захиргааны удирдах	АА-3	Магистр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй	- Менежмент ба удирдахуй /041303, 041304, 041305/ - эрх зүйч /042101, 042103/, - боловсрол /011101, 011435, 011440/, - эдийн засаг /0311/, - үйлдвэрийн технологи /072/.	-Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн байх	Төрийн албанд 12-аас доошгүй жил, үүнээс эрхэлсэн түшмэлийн албан тушаалд 6-аас доошгүй жил ажилсан байх
2	ТАЗ, Ажлын алба	МХШГ	Мэргэжилтэн	1	Төрийн захиргааны гүйцэтгэх	АА-10	Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй	-Эрх зүйч /042/	-Төрийн албанд мэргэшүүлэх зохих багц сургалтад хамрагдаж төгссөн байх	Туслах түшмэлийн албан тушаалд ажилсан бол давуу тал болно.
3	ТАЗ, Ажлын алба	ХНУАГ	Ахлах шинжээч	1	Төрийн захиргааны гүйцэтгэх	АА-7	Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй	-Бизнес ба удирдахуй /041201, 041301, 041304/ -эдийн засаг /031101/, -эрх зүй /0421/, -боловсрол /011101/, -олон улсын харилцаа /031202/, -мэдээлэл, харилцаа холбооны технологиуд /061/,	-Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн байх	Төрийн албанд 6-аас доошгүй жил, үүнээс дэс түшмэлийн албан тушаалд 3-аас доошгүй жил ажилсан байх

4	ТАЗ, Ажлын алба	ССМНСГ	Ахлах мэргэжилтэн	1	Төрийн захиргааны гүйцэтгэх	АА-9	Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй	-Мэдээлэл, харилцаа холбооны технологиуд /06/, -багш, мэдээлэл зүйн боловсрол /011403/, -электроник, автоматжуулалт /0714/, -математик, статистик /054/.	-Төрийн албанд мэргэшүүлэх зохих багц сургалтад хамрагдаж төгссөн байх	Туслах түшмэлийн албан тушаалд ажилсан бол давуу тал болно.
---	--------------------	--------	----------------------	---	-----------------------------------	------	--	---	--	---

---oOo---